



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар
сарын 27 ний өдөр

№ 18

Улаанбаатар
хот

ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛАХ ТУХАЙ

МАХН-ын Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

Монгол Улсын Ерөнхийлөгчид МАХН-аас нэр дэвшсэн Н.Багабандийн
хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсугай.

Хуулбар үнэн. Улс төрийн ажилтан

Л.Баярмагнай



8

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД
МАХН-ААС НЭР ДЭВШСЭН НАЦАГИЙН БАГАБАНДИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

*Шинэ зуун:
Төрийн хэрэг иргэдээсээ
Иргэний амьдрал төрөөсөө*

Шинэ зуунд нийгэм, төрийн байгууллаа боловсронгуй болгох, нийгмийн дэвшил, амгалан тайван, элбэг хангалуун амьдралаа цогцлоохын тулд төр засаг маань, монгол түмэн юу бодож, юуг баримжаалж ажиллах учиртай вэ гэдэг талаар сэтгэж бодож явдаг санаагаа миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд нийт иргэд, ард түмэндээ хандаж гаргасан “Зууны илгээлт”- дээ дурдсан билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд дахин нэр дэвшсэн тул би энэхүү Илгээлтийнхээ үзэл санаа болон Монгол Улсын Их Хурлыг толгойлж байсан, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан туршлагадаа тулгуурлан түрүүчийн хөтөлбөрөө цогцоор үргэлжлүүлж сонгуульд оролцох шинэ хөтөлбөрөө боловсрууллаа.

Төр, иргэдийн хооронд итгэцлийг бэхжүүлэх, төр иргэддээ үйлчилдэг, иргэд нь төрийнхөө толөө зүтгэдэг зарчмыг хэвшүүлж улмаар иргэн бүр бүтээлчээр ходолмөрлөж, элбэг хангалуун, амгалан тайван амьдрах нөхцөлийг төрөөс бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Миний хүсэл бодол, зорилго эрмэлзлэлийг хураангуйлан товъёоглосон эл хөтөлбөр Улсын Их Хурлын бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдан зохицсон бөгөөд хэрэгжих гол үндэс, баталгаа нь үүнд оршино.

ТОЛИЛУУЛАХ НЬ:

*Төр, нийгмийн тогтвортой байдлыг эрхэмлэн ардчиллыг хөгжүүлж,
эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар:*

-Монголын төрийн бодлогын нэгдмэл байдлыг хадгалах үүднээс Улсын Их Хурал, Засгийн газрын тогтвортой үйл ажиллагааг дэмжих бодлого тууштай баримтлах;

9

-Хувь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хангах боломжийг бүрдүүлж, шударга ёсыг чанд баримтлах эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх;

-Үндэсний эв нэгдлийг эрхэмлэн нийгэмд хортой хагарал, сөргөлдөөн гарахаас сэргийлэх;

-Төрийн байгууллагуудын ажиллах чадварыг сайжруулж, засаг төр нь ард түмэндээ ээлтэй байх нөхцлийг бүрдүүлэх;

-Шүүх, хуулийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;

-Эдийн засгийн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, албан тушаалтан холбогдсон хэрэг, маргааныг хянаж шийдвэрлэх ажиллагааг шуурхай болгох, шүүхийн алдаа гарвал цаг тухайд нь илрүүлэн засч залруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-Нийгмийн дэг журмыг хангах, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газрын баримталж буй бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

Улс орны эдийн засгийн чадавхийг сайжруулж, өсөлтийг хангах чиглэлд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогод дэмжлэг үзүүлэх талаар:

-Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр бүтцийн өөрчлөлт хийх;

-Уул уурхай, аялал жуулчлалын салбар, мэдээллийн технологийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх;

-Газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах болон экспортын чиглэлийн үйлдвэрийг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох;

-Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, эрчимжүүлэх бодлогыг дэмжих;

-Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бизнесийн таатай орчинг бүс нутгийн онцлогийг харгалзан бүрдүүлэх;

-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлуулан хэрэгжүүлж эхлэх;

-Монголын иргэд газрынхаа үр шимийг хүртэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх;

-Дэд бүтцийн хүрээнд “Мянганы зам”, эрчим хүчний болон бусад томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Экологийн тэнцвэрт болон аюулгүй байдлыг хангах талаар:

-Газрын хөрсний шим өгөөж, хэвлийн эрдэс баялгийг ашиглахдаа байгаль орчныг нөхөн сэргээж байх зарчмыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх;

-Сав, шим ертөнцдөө элбэрэлтэй хандаж, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах сэтгэл зүйг залуу үедээ төлөвшүүлэх;

- Агаар мандал, хөрс усны бохирдол, цөлжилт, элсний нүүдлээс сэргийлэх, ой мод, нуур тойром, гол усны эх ундрагыг хамгаалах бүхий л арга хэмжээг тусгайлсан бодлоготойгоор үе шаттай хэрэгжүүлэх.

Иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах талаар:

-Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;

-Хүн амын эмзэг давхрааны ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, боловсрол мэргэжил эзэмших эрмэлзлэлийг нь дэмжих ;

-Төрийн тусгай албан хаагчдын нийгмийн баталгааг цаашид сайжруулахад түлхүү анхаарах;

-2001 оныг тахир дутуу иргэдийг халамжлах жил болгон зарласныг дэмжиж тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалах;

-Шинжлэх ухаан, боловсрол, технологийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх;

-Монголын иргэд оюуны үнэ цэнэтэй бүтээл гаргах бололцоо, нөхцөлийг дээшлүүлэх, урамшуулах;

-Үндэсний соёл урлаг, хэл, түүхийн шинжлэх ухааныг онцгойлон анхаарч хөгжүүлэн бичиг үсэг, шашин суртахуун, зан заншлаа өвлөх боломжийг хангах аргаар ард түмнийхээ оюуны дархлаажуулалтыг бататгах;

- 11 58
- Мэдээллийн эрх чөлөөг хангаж, хүртээмжийг нь сайжруулах;
 - Ард түмнийхээ эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа хөдөөгийн иргэд, малчдыг эмнэлгийн суурь үйлчилгээнд хамруулах;
 - Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, олны хүртээл болгох бүх санаачилгыг хөхүүлэн дэмжих.

Хүн амын бүлэг, давхрааг адил тэгш анхаарах талаар:

- Өсвөр залуу, идэр, ахмад үеийнхнийхээ бат нягт холбоог бэхжүүлэх нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх;
- Ахмадаа дээдлэн халамжилж, туршлага, ухааныг нь улсын ажил, иргэний ахуй амьдралд түгээх санал, санаачилга гаргаж хэрэгжүүлэх;
- Залуучуудаа дотоодод болон гадаадад боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэхэд нь бүх талаар туслах, гадаадад ажиллаж амьдарч, суралцаж буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах;
- Эх, эмэгтэйчүүдийн эрх ашгийг дээдэлж, хүйсийн тэгш эрхийг хангах үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Малчид, тариаланчдад үзүүлэх үйлчилгээг өргөжүүлж, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх.

Үндэсний аюулгүй байдлыг хангах талаар:

- XXI зуунд дэлхий дахинаа тохиох даяарчлах үйл явцад Монгол Улс оролцохдоо өөрийгөө хадгалах бүхий л нөхцөлийг бүрдүүлэхийг чармайх;
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд XXI зууны эхэн дэх улс орны амьдрал, гадаад орчны өөрчлөлтийг харгалзан нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөх;
- Хүний аюулгүй байдлыг хангах талаар тусгайлсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Зэвсэгт хүчин, бусад цэргийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгож олон талт чиг үүрэг гүйцэтгэх чадавхийг нь нэмэгдүүлэх;
- Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг төлөвшүүлэн бэхжүүлэх.

Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх талаар:

-Монгол Улсын нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогын залгамж чанарыг ханган хадгалах ;

-Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах;

-Гадаад бодлогод ардын дипломатыг идэвхжүүлэх;

-Улс орныхоо эдийн засгийг хөгжүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцаа, хамтын ажиллагааг оновчтой ашиглах.


* * *

Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийг баримтлан дагаж боловсруулсан төр, түмнийхээ төлөө хүчин зүтгэх хөтөлбөрөө сонгогч Танд толилуулахад ийм байна.

Миний үйл ажиллагаа, хөтөлбөрийг дэмжиж намайг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонговол би урьдын адилаар улс үндэстнийхээ эрх ашгийг дээдлэн, хууль ёс, шударга, төв журмыг баримтлан улс төрийн тогтвортой байдлыг эрхэмлэж, улмаар төр иргэний хэм тэгш таацсан харилцааг төлөвшүүлэхийн төлөө нийт ард түмэн, улс төрийн бүх хүчин, Улсын Их Хурал, Засгийн газартай хамтран идэвхтэй тэмцэн ажиллаж хөтөлбөрөө хэрэгжүүлэх болно.

Шинэ зууны шинэ Монгол Улсын төлөө хамтран зүтгэцгээе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
СОНГУУЛЬД МАХН-ААС НЭР ДЭВШИГЧ



НАЦАГИЙН БАГАБАНДИ